



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ



Хэрэгжүүлэгч :

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих (ICED) төсөл

Улирал тутмын мэдээллийн товхимол
No 1/2024



ICED төслийн танилцуулга

ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН ТАЛТ ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ: БИД ХЭН БЭ?

Монгол улсын эдийн засаг уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа нь хөрөнгө оруулалт ихэнхдээ уул уурхайн томоохон төслүүдэд хийгдэж, экспортод нүүрс, зэсийн баяжмал голлож, уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийг хангаж байгаагаас тодорхой харагддаг. Тиймээс, Монгол Улсын Засгийн газар нь нэг салбараас хэт хамааралтай эдийн засгийн өсөлтийн эрсдэлийг бууруулах зорилгоор эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжиж байна.

Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжсэнээр зах зээл тэлж, бизнесийн өрсөлдөх чадвар сайжирч, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх бөгөөд уул уурхайн бус салбарын хөрөнгө оруулалт болон экспортыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) санхүүжилтээр Германы Олон Улсын Хамтын Ажиллагаа (GIZ) хэрэгжүүлж буй "Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих" төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт техникийн туслалцаа үзүүлж байна. Энэхүү тусламж нь хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулах, төлөвлөх, хөрөнгө оруулалт, худалдааны таатай орчныг бүрдүүлэх, түүнчлэн уул уурхайн салбараас бусад салбарын жижиг дунд бизнес эрхлэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортод гаргахад нь дэмжлэг үзүүлэх юм.

Төслийн танилцуулгыг доорх линкээр үзнэ үү.



ICED ТӨСЛИЙН БАГ ХАМТ ОЛОН



Баруун гар талаас:

Д. Ёндонжамц (Төслийн 3-р бүрэлдэхүүн хэсэг хариуцсан ахлах мэргэжилтэн, ХХБ-тай хамтарсан DeveloPPP төслийн ЖДҮ хариуцсан зөвлөх)

Г.Бүдханд (Төслийн хяналт үнэлгээ, олон нийтийн харилцааны мэргэжилтэн)

Ц.Алтанбат (Төслийн 2-р бүрэлдэхүүн хэсэг хариуцсан ахлах зөвлөх)

Ц.Эрдэнэцэцэг (Төслийн туслах)

А.Амгалан (Төслийн хэрэгжилт хариуцсан захирал, ХХБ-тай хамтарсан DeveloPPP төслийн менежер)

Л.Уранчимэг (Төслийн 1-р бүрэлдэхүүн хэсэг хариуцсан мэргэжилтэн)

Б.Нуржамал (Төслийн менежер)

И.Мөнхбаяр (Монре даатгалтай хамтарсан DeveloPPP төслийн зөвлөх, ХХБ-тай хамтарсан DeveloPPP төслийн санхүүгийн салбар хариуцсан зөвлөх)

ICED төслийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурав

2024 оны 2-р сарын 7-8-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар ХБНГУ-ын Ерөнхийлөгч Ф.В.Штайнмайэр Монгол улсад төрийн айлчлал хийв. Энэ айлчлалын хүрээнд 2024 оны 2-р сарын 7-ны өдөр Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Зүүн Азийн бүсийн захирал Т.Гийлэр, Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар “Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих” техникийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү төсөл нь 2024 оноос эхлэн нийт гурван жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд өмнө нь хэрэгжиж байсан “Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих (PROGRES)” төслийн үргэлжлэл юм.



ICED төслийн түнш байгууллагууд

Эдийн засаг хөгжлийн яам (ЭЗХЯ):

ЭЗХЯ нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийг төлөвлөх, хөгжлийн нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангадаг төрийн захиргааны төв байгууллага юм.

ЭЗХЯ-ны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь Монгол Улсын үндэсний, салбар хоорондын, бүс нутгийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах мэдээлэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсчилсэн хөгжил, аж үйлдвэр, өндөр технологи, инновац, худалдаа, чөлөөт бүс, хилийн боомтын хөгжил, хөрөнгө оруулалтын болон зээл, тусламжийн нэгдсэн бодлогыг тодорхойлж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах юм.

Хөрөнгө оруулалт, худалдааны газар (ХОХГ):

ХОХГ нь Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2023 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

ХОХГ нь:

- Хөрөнгө оруулагч, гадаад худалдаа эрхлэгчдийг бүхий л мэдээллээр хангаж, тусламж үйлчилгээ үзүүлэх,
- Хөрөнгө оруулалт, худалдааны бодлого, эрх зүй, бизнесийн орчныг сурталчлан таниулах,
- Хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Тус газрын нэг цэгийн үйлчилгээний төв нь гадаадын хөрөнгө оруулагчдад улсын бүртгэлийн ерөнхий газар, тагнуулын ерөнхий газар, гадаадын иргэн харьяатын газар, нийгмийн даатгал болон бусад салбарын яам, агентлагуудын төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг олгодог.

ICED төслийн түнш байгууллагууд

Нийслэлийн Жижиг, Дунд Үйлдвэр Үйлчилгээг Дэмжих Төв НӨҮГ

Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ажлын хүрээнд үйлдвэр хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм. Нийслэлийн 9 дүүрэгт Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төвүүдтэй. Монгол улсын нийт жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 69 хувь нь нийслэлд харьяалагддаг ба 674,000 ажлын байрыг бий болгож байна.

Нийслэлийн ЖДҮҮДТ НӨҮГ-ийн үндсэн үйл ажиллагаа бол бизнес эрхлэгчдийг сургалтаар хөгжүүлэх, гадаад, дотоодын үзэсгэлэн арга хэмжээнд оролцуулах замаар борлуулалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай санхүүжилтийн дэмжлэг олгох нь тус газрын үндсэн үйл ажиллагаа юм.



НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР,
ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ НӨҮГ





ТАСАГ,
ЖЛҮЙН ЯАМ

ТӨСӨЛ

ТӨСӨЛТИЙГ

ЗОРИЛГО

Хөрөнгө оруулалт болон экспортыг дэмжих үйлчилгээний хүртээмж нь уул уурхайн бус салбарын БЖДУ болон Гадаад Дотоодын хөрөнгө оруулагчдын дунд сайжирсан байна.

Захиалагч

ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ)

Улаанбаатар

Төсөл хэрэгжих бүс, нутаг

Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)

01/2024 - 12/2026



Олон талт эдийн засаг

Хөрөнгө

ICED төсөл үйл ажиллагааны төлөвлөгөөгөө туншүүдтэйгээ хамтран боловсруулав



2024 оны 2-р сарын 20-23-ны өдрүүдэд ICED төсөл төлөвлөлтийн семинараа амжилттай зохион байгууллаа. Уг семинарт төслийн туншлэгч байгууллагууд болох ХБНГУ-ын Элчин сайдын яам, GIZ, ЭЗХЯ, Хөрөнгө оруулалт худалдааны газар, Нийслэлийн ЖДҮҮДТ НӨҮГ, Худалдаа, хөгжлийн банк, Sparkasse сангийн төлөөллүүд оролцлоо.



Семинарт оролцогчид 2024-2026 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийн талаар санал солилцож, төслийн үйл ажиллагааг төлөвлөсөн юм.



Тус төслөөс эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийн судалгаа хийх, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах мэргэжилтнүүдийг чадавхжуулах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, мэдээлэл түгээх, төр, хувийн хэвшлийн яриа хэлэлцээг хөрөнгө оруулалт, худалдааг дэмжих хэрэгсэл болгон хөгжүүлэх, ЖДҮ эрхлэгчдийн экспортын боломж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, уул уурхайн бус салбарын ЖДҮ эрхлэгчдийг экспортын бэлэн байдлыг хангах зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөв.



Тогтвортой санхүүжилтийг дэмжих төсөл хэрэгжинэ



Монгол Улс дахь Жижиг, дунд бизнес (ЖДБ) эрхлэгчдийг чадавхжуулах, тогтвортой санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах SFME төслийг хамтран хэрэгжүүлэхээр Худалдаа, хөгжлийн банк (ХХБ) болон GIZ нар төсөл хэрэгжүүлэх гэрээнд 2024 оны 2-р сарын 29-д гарын үсэг зурлаа.

Уг төсөл нь 2024 оны 3-р сараас 2026 оны 6-р сар хүртэл хугацаанд хэрэгжих бөгөөд Монгол улсын тогтвортой хөгжил болон ногоон ирээдүйд чиглэсэн ЖДБ-ийг дэмжих, ЖДБ эрхлэгчдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой юм. Мөн зорилтот сургалт, семинар, уулзалтууд нь ЖДБ эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, мөн банкны ажилтнуудын ЖДБ-ийн тогтвортой санхүүжилтийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэж байна.

Төслийг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны төр, хувийн хэвшлийг дэмжих DeveloPPP.de хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын ХХБ-тай хамтран санхүүжүүлж, хэрэгжүүлнэ.



develoPPP

Where business meets development.

TDB
TRADE & DEVELOPMENT BANK

DeveloPPP.de хөтөлбөр нь түншлэлийн зарчмаар, нийгэмд эерэг үр дүн, нөлөөтэй төсөл хөтөлбөрүүдийг хувийн хэвшилтэй хамтран санхүүжүүлж, хэрэгжүүлдэг бол GIZ нь ХБНГУ-ын засгийн газрын санхүүжилтээр хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэгч байгууллага юм.

ХХБ: ХХБ нь “Харилцагч төвтэй банк болох” стратеги, чиглэлийн хүрээнд Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас тогтвортой бөгөөд зорилтот эх үүсвэрийг татан төвлөрүүлж, ЖДБ-ийг санхүүжүүлэх, бизнесийг өргөжүүлэх, үүний хүрээнд санхүүжилтийн эко системийг бий болгох, санхүүгийн уламжлалт болон дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, зах зээл дэх жижиг, дунд сегментийг тэлэх зорилготой ажиллаж байна.

Мөн байгаль орчин, нийгэмд ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагааг санхүүжүүлж, хүний эрх, хөдөлмөрийн эрхийн хамгаалал болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, нягт хамтын ажиллагааны үр дүнд харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулж “Ногоон банк” болох зорилгын төлөө хувь нэмрээ оруулж байна.

Эдийн Засгийн Хөгжлийн Яаманд ажиллах зөвлөхийг танилцуулж байна



Доктор Рамон Брюсселер 2024 оны 2-р сараас эхлэн хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ЭЗХЯ, Хөрөнгө, оруулалт, худалдааны газартай хамтран ажиллана.

Рамон Брюсселер нь менежментийн болон хөрөнгө оруулалтын чиглэлээр 30 орчим жил ажилласан туршлагатай. Тэрээр Ази тивд 20 гаруй жил ажилласан ба Лаос дахь Европын Худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирлаар 8 жил, хувийн хэвшлийн болон байгууллагуудын зөвлөхөөр GIZ, НҮБ зэрэг олон улсын байгууллагуудад ажиллаж байсан туршлагатай нэгэн юм.

GIZ нь нийгмийн хариуцлагын хүрээнд

Монгол дахь GIZ нь “Үндэстний ажилтнуудын зөвлөл” (ҮАЗ)-ийг 2 жил тутам сонгон ажилуулдаг. 2022-2024 онуудад сонгогдсон ҮАЗ-ийн зөвлөл нь 2 томоохон сайн үйлсийн аяныг амжилттай зохион байгуулсан юм.

Эхнийх нь үерийн гамшигт өртсөн Баянзүрх дүүргийн хорооны сурагчдад хичээлийн хэрэгсэл гардуулах аян байсан бол хоёр дах нь Нийслэлийн 25-р тусгай сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх аян байв.

GIZ ICED төсөл нь өөрийн оффист хэрэглэгдэж байсан 10 гаруй нэр төрлийн эд хогшлыг Нийслэлийн 25-р тусгай сургуульд хандивлав. Бидний хандивыг тус сургуулийн багш, ажилчид хүлээн авч, сургуулийнхаа анги, танхимд хуваарилан хэрэглэж байгаа бөгөөд аяныг зохион байгуулсан, оролцсон бүх хүнд чин сэтгэлийн талархлаа илэрхийлснийг уламжилж байна. Энэхүү аянд идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа!



Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих (ICED) төсөл



Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг (GIZ)

Огноо: 2024 оны 4-р сар

Дизайн/Зураг: GIZ ICED төсөл

Холбоо барих: Г. Бүдханд
“Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих”
төсөл
3-р давхар, 38-р байр, Нэгдсэн Үндэстний
гудамж,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 210646, Монгол улс

Утас: (+976) 77117704

И-мэйл: gurtsog.budkhand@giz.de

Веб: www.giz.de/mongolia